



МОНГОЛ УЛСЫН САЙД,  
ОЛИМП, НИЙТИЙН БИЕЙН ТАМИР, СПОРТЫН  
ҮНДЭСНИЙ ХОРООНЫ ДАРГЫН ТУШААЛ

2023 оны 02 сарын 10 өдөр

Дугаар А/03

Улаанбаатар хот

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийг үндэслэн ТУШААХ нь:

1.Хувь хүний бие бялдрын хөгжлийг дэмжих, идэвхтэй амьдралын хэв маягийг хэвшүүлэхэд өдөр тутмын хөдөлгөөн, дасгалын жишиг загварыг шинэчлэх үүрэг бүхий ажлын хэсгийг байгуулж удирдлага, хяналт, арга зүйгээр хангаж ажиллахыг Биеийн тамир, спортын улсын хорооны харьяа Спортын анагаах ухаан, эрдэм шинжилгээний төвийн дарга /Б.Эрдэнэванчиг/-д даалгасугай.


2.Ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг нэгдүгээр, ажлын төлөвлөгөөг хоёрдугаар, удирдамжийг гуравдугаар, ажил үүргийн хуваарийг дөрөвдүгээр хавсралтаар тус тус баталсугай.

3.Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Олимп, нийтийн биеийн тамир, спортын Үндэсний хорооны ажлын албаны дарга (Э.Тэмүүжин)-д үүрэг болгосугай.

Монгол Улсын сайд, Олимп,  
нийтийн биеийн тамир, спортын  
Үндэсний хорооны дарга



Б.БАТ-ЭРДЭНЭ



Олимп, нийтийн биеийн тамир, спортын Үндэсний хорооны даргын 2023 оны 4 дугаар сарын 10-ны өдрийн 1/03 тоот тушаалын нэгдүгээр хавсралт

**ӨДӨР ТУТМЫН ХӨДӨЛГӨӨН, ДАСГАЛЫН ЖИШИГ ЗАГВАРЫГ ШИНЭЧЛЭХ АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН**

Дарга:

Б.Эрдэнэваанчиг Биеийн тамир, спортын улсын хорооны харьяа Спортын анагаах ухаан, эрдэм шинжилгээний төвийн дарга,

Гишүүд:

С.Өнөрсайхан Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төвийн захирал  
С.Мөнх-Эрдэнэ Биеийн тамир, спортын улсын хорооны Бодлого, төлөвлөлтийн газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч  
О.Баасан Биеийн тамир, спортын улсын хорооны Биеийн тамирын бодлогын хэрэгжилтийн хэлтсийн дарга  
Б.Батцэнгэл Биеийн тамир, спортын улсын хорооны харьяа Спортын анагаах ухаан, эрдэм шинжилгээний төвийн Эрдэм шинжилгээ, сургалт судалгааны албаны дарга  
С.Жаргалсайхан НЭМГ, Урьдчилан сэргийлэлт, хяналт зохицуулалтын хэлтсийн эрүүл мэндийн боловсрол, салбар хоорондын хамтын ажиллагаа хариуцсан мэргэжилтэн  
Ж.Ганболд Нийслэлийн биеийн тамир, спортын газрын дарга  
Г.Энхсайхан Монгол улсын боловсролын их сургуулийн Биеийн тамирын сургуулийн захирал,  
Д.Даваалхам Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургуулийн Нийгмийн, эрүүл мэндийн сургуулийн захирал  
Г.Сүхбат Аварга дээд сургуулийн дэд захирал  
Х.Батбаяр Шинжлэх ухаан, технологийн их сургуулийн Механик тээврийн сургуулийн Техник механикийн тэнхимийн багш, Биомеханикийн лабораторийн эрхлэгч  
Б.Долгормаа "Голден Жим" ХХКомпанийн захирал  
Г.Ерөөлбат Монголын гимнастикийн холбооны Гүйцэтгэх захирал  
Г.Бүрэнбилэг "Эрүүл Монгол хүн" хөдөлгөөний зохицуулагч

Нарийн бичгийн дарга:

Б.Ганзориг БТСУХ-ны харьяа Спортын анагаах ухаан, эрдэм шинжилгээний төвийн эрдэм шинжилгээний ажилтан,  
Э.Алтанзул Олимп, нийтийн биеийн тамир, спортын Үндэсний хорооны Ажлын албаны мэргэжилтэн,

Олимп, нийтийн биеийн тамир, спортын Үндэсний хорооны даргын, 2023 оны ... дугаар сарын ... -ны өдрийн ... тоот тушаалын хоёрдугаар хавсралт



**ӨДӨР ТУТМЫН ХӨДӨЛГӨӨН, ДАСГАЛЫН ЖИШИГ ЗАГВАРЫГ ШИНЭЧЛЭХ  
АЖЛЫН ХЭСГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ**

№	Хийгдэх ажил	Хугацаа	Хариуцах ажилтан	Хяналт тавих албан тушаалтан
1	Холбогдох стандарт, нормативыг судлах, хууль эрх зүйн зохицуулалтыг хянах, хүн, санхүү, тоног хэрэгслийн нөөцийн тооцоолол хийх,	III/01 - IV/01	О.Баасан С.Мөнх-Эрдэнэ Б.Өлзийбаяр Ж.Ганболд Г.Бүрэнбилэг Э.Алтанзул	Э.Тэмүүжин Б.Эрдэнэваанчиг
2	Спортын шинжлэх ухаан, нийтийн биеийн тамир, иргэдийн бие бялдрын хөгжил, эрүүл мэндийн чиглэлээр хийгдсэн судалгааг нэгтгэх, гадаадын ижил төрлийн судалгаа, дасгалын жишиг загварыг харьцуулан судлах,	III/01 – V/01	Б.Батцэнгэл С.Өнөрсайхан С.Жаргалсайхан Г.Энхсайхан Д.Даваалхам Г.Сүхбат Х.Батбаяр Б.Долгормаа Г.Ерөөлбат Б.Ганзориг	Б.Эрдэнэваанчиг
3	Судалгааны өгөгдөлд дүн шинжилгээ хийсний дараа шаардлагатай тохиолдолд зарим чиглэлээр суурь судалгааг хийх,	IV/01 - VI/30	Д.Баярболд С.Өнөрсайхан Г.Энхсайхан Д.Даваалхам Г.Сүхбат Х.Батбаяр	Б.Эрдэнэваанчиг
4	Судалгааны үр дүнг эрдэмтэн судлаачдын төлөөлөлд хэлэлцүүлэх, ярилцлага зохион байгуулах, санал нэгтгэх,	V/30 – VII/09	О.Баасан С.Мөнх-Эрдэнэ Б.Ганзориг Г.Ерөөлбат Б.Долгормаа Э.Алтанзул	Б.Эрдэнэваанчиг
5	Спортын шинжлэх ухааны ололт нотолгоо, эрдэм шинжилгээ, судалгааны үр дүнд суурилсан байдлаар дасгалын жишиг загварыг боловсруулах	VII/20 – VIII/25	Б.Батцэнгэл Ж.Ганболд С.Өнөрсайхан Г.Энхсайхан Д.Даваалхам Г.Сүхбат Х.Батбаяр	Б.Эрдэнэваанчиг
6	Судалгааны үр дүнд суурилсан байдлаар боловсруулсан дасгалын жишиг загварыг төрийн болон төрийн бус байгууллага, спорт холбоодын төлөөлөлд танилцуулах, санал авах, саналыг нэгтгэх	VIII/25 – IX/10	О.Баасан С.Мөнх-Эрдэнэ Б.Ганзориг Г.Ерөөлбат Б.Долгормаа Э.Алтанзул	Б.Эрдэнэваанчиг

7	Судалгааны үр дүнд бий болсон дасгалын жишиг загварыг эцсийн байдлаар боловсруулан ажлын хэсэгт хэлэлцүүлэх	IX/10- IX/25	Б.Эрдэнэваанчиг С.Өнөрсайхан Г.Энхсайхан Д.Даваалхам Г.Сүхбат Х.Батбаяр	Э.Тэмүүжин
8	Хувь хүний бие бялдрын хөгжлийг дэмжих, идэвхтэй амьдралын хэв маягийг хэвшүүлэх өдөр тутмын хөдөлгөөн, дасгалын жишиг загварыг Олимп,нийтийн биеийнтамир, спортын үндэсний хороогоор батлуулах	IX/25 - X/05	Б.Эрдэнэваанчиг О.Баасан С.Мөнх-Эрдэнэ Э.Алтанзул	Э.Тэмүүжин
9	Хувь хүний бие бялдрын хөгжлийг дэмжих, идэвхтэй амьдралын хэв маягийг хэвшүүлэх өдөр тутмын хөдөлгөөн, дасгалын жишиг загварыг "Иргэдийн бие бялдрын түвшин тогтоох сорилын төв"-ийн үйл ажиллагаанд нэвтрүүлэх, олон нийтэд сурталчлан таниулах	2023 оны X/10 – 2024 оны XII/31	О.Баасан Г.Ерөөлбат Б.Долгормаа	Э.Тэмүүжин
10	Хөдөлгөөн, дасгалын шинэчилсэн загварыг турших, эхний үе шатны судалгааг боломжит үзүүлэлтээр хийн үр дүнг тооцох	2023 оны X/10 – 2024 оны II/01	О.Баасан Б.Батцэнгэл С.Өнөрсайхан Д.Даваалхам Г.Ерөөлбат Б.Долгормаа	Б.Эрдэнэваанчиг
11	Хувь хүний бие бялдрын хөгжлийг дэмжих, идэвхтэй амьдралын хэв маягийг хэвшүүлэх өдөр тутмын хөдөлгөөн, дасгалын жишиг загварыг хэрэглэсэн иргэдийн түүвэр судалгааг сорилын төвийн мэдээлэлд тулгуурлан улирал нэгтгэн үр дүнг тооцох	2024 оны I/01 – XII/20	О.Баасан Б.Батцэнгэл С.Өнөрсайхан Д.Даваалхам	Б.Эрдэнэваанчиг

Олимп, нийтийн биеийн тамир, спортын Үндэсний хорооны даргын 2023 оны ... дугаар сарын ... -ны өдрийн ... тоот тушаалын гуравдугаар хавсралт



## **ӨДӨР ТУТМЫН ХӨДӨЛГӨӨН, ДАСГАЛЫН ЖИШИГ ЗАГВАРЫГ ШИНЭЧЛЭХ АЖЛЫН ХЭСГИЙН АЖЛЫГ ЗОХИОН БАЙГУУЛАХ УДИРДАМЖ**

### **Нэг. Зорилго**

- 1.1. Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2010 оны 53 дугаар зарлиг, “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын зорилт 2.2, Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрийн 2.1.1, 2.2.1, Биеийн тамир, спортын тухай хуулийн 10.1.9-т заасныг хэрэгжүүлэх хүрээнд хувь хүний бие бялдрын хөгжлийг дэмжих, идэвхтэй амьдралын хэв маягийг хэвшүүлэх өдөр тутмын хөдөлгөөн, дасгалын жишиг загварыг бий болгох замаар хүн амд эрүүл аж төрөх зан үйлийг хэвшүүлэх, иргэнийг өвчлөлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор идэвхтэй хөдөлгөөн хийхэд уриалах ажлыг зохион байгуулах нь уг ажлын зорилго юм.

### **Хоёр. Зорилт**

- 2.1. Хувь хүний бие бялдрын хөгжлийг дэмжих, идэвхтэй амьдралын хэв маягийг хэвшүүлэх өдөр тутмын хөдөлгөөн, дасгалын жишиг загварыг бий болгох зорилгын хүрээнд дараах зорилтуудыг хэрэгжүүлнэ:
  - 2.1.1. Хувь хүний бие бялдрын хөгжлийг дэмжих, идэвхтэй амьдралын хэв маягийг хэвшүүлэх өдөр тутмын хөдөлгөөн, дасгалын жишиг загварыг боловсруулахад шаардлагатай судалгааг хийх;
  - 2.1.2. Хувь хүний бие бялдрын хөгжлийг дэмжих, идэвхтэй амьдралын хэв маягийг хэвшүүлэх өдөр тутмын хөдөлгөөн, дасгалын жишиг загварыг боловсруулах;
  - 2.1.3. Идэвхтэй амьдралын хэв маягийг хэвшүүлэх өдөр тутмын хөдөлгөөн, дасгалын жишиг загварыг бие бялдрын түвшин тогтоох сорилын үр дүнтэй уялдуулах, хувь хүний бие бялдарын хөгжилд тохируулан зөвлөгөө өгөх, тохирох дасгалыг санал болгох, сорилын төвд жишиг дасгалыг хийлгэх арга, аргачлалыг боловсруулах;
  - 2.1.4. Спортын шинжлэх ухааны ололт, нотолгоонд суурилан боловсруулсан хувь хүний бие бялдрын хөгжлийг дэмжих, идэвхтэй амьдралын хэв маягийг хэвшүүлэх өдөр тутмын хөдөлгөөн, дасгалын жишиг загварыг олон нийтэд сурталчлан таниулах төлөвлөгөөг боловсруулах;

### **Гурав. Зорилтын хүрээнд хийж хэрэгжүүлэх ажлууд:**

- 3.1. Хувь хүний бие бялдрын хөгжлийг дэмжих, идэвхтэй амьдралын хэв маягийг хэвшүүлэх өдөр тутмын хөдөлгөөн, дасгалын жишиг загварыг боловсруулахад шаардлагатай судалгааг хийх;

- 3.1.1. Холбогдох стандарт, нормативыг судлах, хууль эрх зүйн зохицуулалтыг хянах;
- 3.1.2. Спортын шинжлэх ухаан, нийтийн биеийн тамир, иргэдийн бие бялдрын хөгжил, эрүүл мэндийн чиглэлээр өмнө хийгдсэн судалгааг нэгтгэх;
- 3.1.3. Гадаадын ижил төрлийн судалгаа, дасгалын жишиг загварыг харьцуулан судлах, шаардлагатай тохиолдолд зарим чиглэлээр суурь судалгааг хийх, үр дүнг нэгтгэн эрдэм шинжилгээ судалгааны сан үүсгэх;
- 3.2. Хувь хүний бие бялдрын хөгжлийг дэмжих, идэвхтэй амьдралын хэв маягийг хэвшүүлэх өдөр тутмын хөдөлгөөн, дасгалын жишиг загварыг боловсруулах зорилтын хүрээнд дараах ажлыг хийж хэрэгжүүлнэ.
  - 3.2.1. Спортын шинжлэх ухааны ололт нотолгоо, эрдэм шинжилгээ, судалгааны үр дүнд суурилсан байдлаар дасгалын жишиг загварыг боловсруулах, ;
  - 3.2.2. Дасгалын жишиг загварт төрийн болон төрийн бус байгууллага, спорт холбоодын төлөөллийн оролцоог хангах үүднээс санал, санаачлагыг тусган эцэслэн батлуулах;
- 3.3. Идэвхитэй амьдралын хэв маягийг хэвшүүлэх өдөр тутмын хөдөлгөөн, дасгалын жишиг загварыг бие бялдрын түвшин тогтоох сорилын үр дүнтэй уялдуулах, хувь хүний бие бялдарын хөгжилд тохируулан зөвлөгөө өгөх, тохирох дасгалыг санал болгох, сорилын төвд жишиг дасгалыг хийлгэх арга, аргачлалыг боловсруулах;
  - 3.3.1. Бие бялдарын түвшин тогтоох сорилын үр дүнг үндэслэн хувь хүн тус бүрийн бие бялдарын хөгжилд тохирсон зөвлөгөө, зөвлөмжийг боловсруулах, тухайн хүнд санал болгох идэвхитэй хөдөлгөөн, дасгалын жорыг боловсруулах;
  - 3.3.2. Сорилын төвд ажиллах боловсон хүчинг бэлтгэхэд шаардлагатай гарын авлага, сургалтын материалыг боловсруулах;
  - 3.3.3. Бие бялдрын түвшин тогтоох сорилын төвийн үйл ажиллагаанд дасгалын жишиг загварыг хэрэглэх арга, аргачлал, зааварыг боловсруулах;
- 3.4. Спортын шинжлэх ухааны ололт, нотолгоонд суурилан боловсруулсан хувь хүний бие бялдрын хөгжлийг дэмжих, идэвхтэй амьдралын хэв маягийг хэвшүүлэх өдөр тутмын хөдөлгөөн, дасгалын жишиг загварыг олон нийтэд сурталчлан таниулах төлөвлөгөөг боловсруулах ажлын хүрээнд дараах ажлыг хийж хэрэгжүүлнэ:
  - 3.4.1. Хувь хүний бие бялдрын хөгжлийг дэмжих, идэвхтэй амьдралын хэв маягийг хэвшүүлэх өдөр тутмын хөдөлгөөн, дасгалын жишиг загварыг олон нийтэд сурталчлан таниулах төлөвлөгөөг гаргах.
  - 3.4.2. Хувь хүний бие бялдрын хөгжлийг дэмжих, идэвхтэй амьдралын хэв маягийг хэвшүүлэх өдөр тутмын хөдөлгөөн, дасгалын жишиг загварыг бие бялдарын түвшин тогтоох сорилын төвийн цахим системд холбох;

#### **Дөрөв. Зохион байгуулах хугацаа**

- 4.1. Хувь хүний бие бялдрын хөгжлийг дэмжих, идэвхтэй амьдралын хэв маягийг хэвшүүлэх өдөр тутмын хөдөлгөөн, дасгалын жишиг загварыг бий болгох ажлыг 2023 оны 02 дугаар сарын 01-ний өдрөөс 2023 оны 10 сарын 05-ны өдрийг хүртэл гүйцэтгэж бие бялдарын түвшин тогтоох сорилын төвийн үйл ажиллагаанд нэвтрүүлнэ.

- 4.2. Идэвхитэй хөдөлгөөн, дасгалын жишиг загварыг бие бялдарын түвшин тогтоох сорилын төвийн үйл ажиллагаанд 2023 оны 10 сарын 10-ны өдрөөс эхлэн нэвтрүүлсэний дараагаар эхний үе шатны түүвэр судалгааг бие бялдарын хөгжлийн үндсэн үзүүлэлтээр 2024 оны 3 сарын 31-ний өдрийн дотор хийнэ.
- 4.3. Хувь хүний бие бялдарын хөгжлийг дэмжих, идэвхтэй амьдралын хэв маягийг хэвшүүлэх өдөр тутмын хөдөлгөөн, дасгалын жишиг загварыг дагуу дасгал хийсэн иргэдийн түүвэр судалгааг сорилын төвийн мэдээлэлд тулгуурлан 2024 оны 01 сарын 01-ээс 2023 оны 12 сарын 31-ний өдрийг хүртэл улирал тутам хийж, үр дүнг тооцно.

#### **Тав. Санхүүжилт**

- 5.1. Хувь хүний бие бялдарын хөгжлийг дэмжих, идэвхтэй амьдралын хэв маягийг хэвшүүлэх өдөр тутмын хөдөлгөөн, дасгалын жишиг загварыг боловсруулах, үр дүнгийн үнэлгээ хийх, эрдэм шинжилгээ, судалгааны ажлыг гүйцэтгэх санхүүжилтийг гүйцэтгэлийн төлөвлөгөөндөө тусган ажиллана.

#### **Зургаа. Удирдлага, зохион байгуулалт**

- 6.1. Ажлын хэсгийн дарга нь ажлын хэсгийн хурлыг зарлан хуралдуулж, хурлаас гарсан шийдвэрийг Олимп, нийтийн биеийн тамир, спортын үндэсний хорооны дарга, Биеийн тамир, спортын улсын хорооны дарга нарыг мэдээллээр хангаж ажлын хэсгийн гишүүдийг удирдлага арга зүй, ажиллах нөхцлийг бүрдүүлэнэ.
- 6.2. Ажлын хэсгийн гишүүд төлөвлөгөөнд тусгагдсан өөрт ноогдсон ажлыг цаг тухайд нь чанартай гүйцэтгэн ажлын хэсгийн хуралд тайлагнаж, хурлаас гарах аливаа шийдвэрт санал бодлоо илэрхийлэх, тусгах бөгөөд хурлын шийдвэрийг эцэслэхдээ холбогдох хууль, дүрмийн дагуу шинжлэх ухаанч, бодит судалгаа дүгнэлтэд үндэслэн олонхын байр суурийг тусган гаргана.

#### **Долоо. Хүлээгдэж буй үр дүн**

- 7.1. Хувь хүний бие бялдарын хөгжлийг дэмжих, идэвхтэй амьдралын хэв маягийг хэвшүүлэх өдөр тутмын хөдөлгөөн, дасгалын жишиг загварыг боловсруулан бие бялдарын түвшин тогтоох сорилын төвийн үйл ажиллагаанд нэвтрүүлсэнээр иргэдийн хөдөлгөөн дасгал хийх сонирхол үүсч бодитоор хичээллэх эерэг нөлөө үзүүлэхээс гадна өөрчлөлтийг хянах, сайжруулах, идэвхтэй хэв маяг хэвшүүлэх боломж бүрдэнэ.
- 7.2. Иргэдэд идэвхитэй амьдралын хэв маягийг хэвшүүлэх, зөв дадал бий болгох, эрүүл мэнддээ анхаарах хандлагад эерэг нөлөө үзүүлнэ.
- 7.3. Бие бялдарын түвшин тогтоох сорилын төвийн өгөгдөлд тулгуурлан иргэдийн эрүүл мэнд, бие бялдарын хөгжилд гарсан өөрчлөлт, идэвхитэй хөдөлгөөн, дасгалын жишиг загварын нөлөөллийг судлан шинжлэх ухааны эрдэм шинжилгээ, судалгааны ажил хийх нөхцөл бүрдэнэ.
- 7.4. Идэвхитэй хөдөлгөөн, дасгалыг өдөр тутмын хэвшүүлсэн иргэдийн эрүүл мэнд, бие бялдарын хөгжилд гарсан өөрчлөлтийг нэгдсэн мэдээллийн санд бүртгэж тогтмол хянаснаар дасгал хөдөлгөөний үр дүнд дүн шинжилгээ, үнэлгээ хийх, цаашид дасгал, хөдөлгөөнийг шинэчлэх, боловсронгуй болгох боломж бүрдэнэ.

- 7.5 Хувь хүний бие бялдрын хөгжлийг дэмжих, идэвхтэй амьдралын хэв маягийг хэвшүүлэх өдөр тутмын хөдөлгөөн, дасгалын үр дүнд тулгуурлан төрийн болон мэргэжлийн байгууллагуудаас идэвхтэй хөдөлгөөн, нийтийн биеийн тамирын үйл ажиллагааг төлөвлөх, бодлогын бичиг баримт боловсруулахад дэмжлэг болно.
- 7.6 Хөдөлгөөн дасгал хийж буй иргэдийн тоо, тэдгээрийн бодит оролцоо, өөрчлөлт, цар хүрээний тэлэлтийг цахимжуулан салбарын ажилтнуудын ажлын үр дүнг тооцоолох тогтолцоо бүрдсэнээр төрийн төв, орон нутгийн байгууллагаас биеийн тамирын салбарыг үр дүнгээр санхүүжүүлэх зарчим нэвтрүүлэх суурь тавигдана.

--ooOoo--



Олимп, нийтийн биеийн тамир, спортын Үндэсний хорооны даргын 2023 оны ... дугаар сарын ... -ны өдрийн ... тоот тушаалын дөрөвдүгээр хавсралт

## **АЖЛЫН ХЭСГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТЛЭГ ЖУРАМ, ГИШҮҮДИЙН АЖИЛ ҮҮРГИЙН ХУВААРЬ**

Тус ажлын хэсэг нь Олимп, нийтийн биеийн тамир, спортын Үндэсний хорооны даргын баталсан бүрэлдэхүүнтэйгээр үйл ажиллагаагаа явуулна.

### **Нэг. Нийтлэг журам:**

1. Ажлын хэсгийн шийдвэр гаргах үйл ажиллагаа хуралдаан байна.
2. Хурлыг гишүүдийн 50-с доошгүй хувийн бүрэлдэхүүнтэй хийнэ.
3. Цаг үеийн тулгамдсан асуудал шийдвэрлэх шаардлагатай асуудлаар тухай бүр ажлын хэсгийн дарга хурлыг зарлан хуралдуулж болно.
4. Ажлын хэсгийн дарга хуралд оролцох боломжгүй, зайлшгүй тохиолдолд тухайн хурлын даргалагчийг ажлын хэсгийн гишүүдийн олонхын саналаар сонгож болно.
5. Хэлэлцэж буй асуудлаар ажлын хэсгийн гишүүдийн олонхын саналыг үндэслэн эцсийн дүгнэлт хийж, хурлын шийдвэр, тогтоол, тэмдэглэл гаргана.
6. Хуралдааныг цахим болон танхим гэсэн хэлбэрээр зохион байгуулж болно.
7. Хурлын тэмдэглэлийг ажлын хэсгийн даргаар хянуулж гарын үсэг зурж баталгаажуулна.
8. Хурлаар хэлэлцэх асуудлыг нарийн бичгийн дарга гишүүдэд урьдчилан тарааж танилцуулан бэлтгэлийг хангана.
9. Гишүүдийн ажил үүргийн хуваарь:
  - Удирдлага зохион байгуулалт (Б.Эрдэнэваанчиг)
  - Төлөвлөлт, боловсруулалт (О.Баасан, С.Мөнх-Эрдэнэ, Д.Баярболд, Б.Өлзийбаяр)
  - Эрдэм шинжилгээ, судалгаа (Б.Батцэнгэл, Д.Баярболд, С.Өнөрсайхан, Г.Энхсайхан, Д.Даваалхам, Г.Сүхбат, Х.Батбаяр)
  - Дасгалын жишиг загварыг боловсруулалт (Ж.Ганболд, С.Өнөрсайхан, Г.Энхсайхан, Д.Даваалхам, Г.Сүхбат, Х.Батбаяр, Г.Ерөөлбат, Б.Долгормаа)
  - Дасгалын жишиг загварыг сорилын төвийн үйл ажиллагаанд нэвтрүүлэх, олон нийтэд сурталчлах (О.Баасан, С.Мөнх-Эрдэнэ, Г.Ерөөлбат, Б.Долгормаа)
  - Хэлэлцүүлэг (О.Баасан, С.Мөнх-Эрдэнэ, Б.Ганзориг, Г.Ерөөлбат, Б.Долгормаа)
  - Хурал, уулзалт, протокол (Б.Ганзориг, Э.Алтанзул)

Гишүүд энэхүү ажлын үүргийн хуваарийн дагуу төлөвлөгөөнд заагдсан ажил үүргийг хийж гүйцэтгэнэ.

## **Хоёр. Ажлын хэсгийн гишүүдийн ажлын хуваарь:**

### 1. Дарга:

- Үйл ажиллагааг удирдан зохион байгуулах;
- Үйл ажиллагаанд хяналт тавьж, хэрэгжилтийн явц, төлөвлөгөөний биелэлтэд хяналт тавих;
- Ажлын хэсгийн хурал зарлах, хуралдуулах, шийдвэрлэх;
- Ажлын хэсгийн үйл ажиллагаанд тулгарч байгаа асуудлуудыг шийдвэрлэх;
- Холбогдох шийдвэрийг гаргах;

### 2. Ажлын хэсгийн гишүүд:

- Хариуцсан ажил, үүргийг цаг тухайд нь хийх, зохион байгуулан гүйцэтгэх;
- Төлөвлөгөөнд тусгагдсан ажлыг хэрэгжүүлэхэд идэвх, санаачилгатай ажиллах;
- Ажлын хэсгийн үйл ажиллагаанд оролцон тусалж, дэмжих;
- Судалгаа, төлөвлөлт, боловсруулалтад хамтран ажиллах;

### 3. Нарийн бичгийн дарга:

- Ажлын хэсгийн өдөр тутмын үйл ажиллагааг чиглүүлэх;
- Ажлын хэсгийн үйл ажиллагааг уялдуулан зохион байгуулна;
- Ажлын хэсгийн гишүүдийг зайлшгүй мэдээллээр хангах;
- Ажлын хэсгийн үйл ажиллагаатай холбоотой бичиг баримт, түүний боловсруулалтыг хийх;
- Ажлын хэсгийн үйл ажиллагаатай холбоотой мэдээллийг хэвлэл мэдээллийн ажилтан болон мэдээллийн хэрэгслүүдэд өгөх;